



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/194

Хэрлэн сум

Бүтээн байгуулалттай холбоотой санал
гомдлыг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргах өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулсан барилга угсралтын ажилтай холбоотой санал гомдлыг хүлээн авах, судалж шийдвэрлэх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Нарийн

бичиг:

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн олон нийт, үйлдвэрийн барилга, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч

2. Хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, санал гомдлыг шийдвэрлэсэн талаарх ажлын тайланг тухай бүр Засаг даргад, Засаг даргын дэргэдэх бүтээн байгуулалтын ажлын зөвлөлд танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

D:\My Documents\Захирамж-2025

231010661



۵۷ ۷۵ ۵۵۷
 یمن یمن، لک یمن و

[illegible][illegible]

سختیوں میں ان کے ہر سچے سچے دوست، اور ہر سچے سچے دشمن کو مطلع کیا۔

مسلم

[illegible]

سندھ میں جیسے سجنڑا، ندر سینڑا، ندر آسن من رنرل من وچینڑا، مہمویسپر . ونجور
مہتممپر ندر سپر من اہر اندر . مہتممندر ندر وچینڑا . صت وچمت ندر وچینڑا
سندھ مسپر پندر عہر

[illegible]

مستقیم از آنست که سبب آنرا، و نیز با بعضی و غیره در آنست که بعضی از بعضی .
بعضی از بعضی در آنست که بعضی از بعضی

[illegible][illegible]

Handwritten signature: *محمد بن عبد الله*